МЭДЭЭ · 2025 оны 2-р сарын 12

ЭМГЭНЭЛ



ЭМГЭНЭЛ



ДАГВАДОРЖИЙН ЖАМБАЛДОРЖ
(1951 - 2025)

Монгол Улсын Гавьяат хуульч, ахмад прокурор Дагвадоржийн Жамбалдорж нь өвчний улмаас таалал төгсөж, нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Тэрбээр Төв аймгийн Дэлгэрхаан суманд 1951 онд төрж, 1984 онд Монгол Улсын Их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсжээ.

Д.Жамбалдорж нь 1972-1979 онд Төв аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, 1984-1997 онд Төв аймгийн прокурорын орлогч прокурор, 1997-2000 онд Төв аймгийн прокурор, 2000-2001 онд Улсын ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2001-2006 онд Төв аймгийн прокурорын орлогч прокурор, 2006-2011 онд мөн аймгийн прокурорын газарт туслах прокурор, хяналтын прокуророор тасралтгүй ажиллаж, аймгийн аварга хуульчаар хоёр удаа шалгарсан тэргүүний ахмад прокурор байлаа.

Түүний прокурорын байгууллагад оруулсан хувь нэмэр, үнэтэй хөдөлмөрийг нь төр засгаас өндрөөр үнэлэн Алтан гадас одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж, Монгол Улсын Гавьяат хуульч цол хүртээсэн юм.

Монгол Улсын Гавьяат хуульч, ахмад прокурор Д.Жамбалдоржийн хөдөлмөрч, ажилч хичээнгүй, шударга, зарчимч, эгэл даруу, хүнлэг, нөхөрсөг зан чанар нь бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд
гүн эмгэнэл илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1081